

**ХӨСӨГ ТРЕЙД ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 05 сар 21 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурлыг 2021 оны 05-р сарын 21-ний өдрийн 16.00 минутанд Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо, Эрчим хүчний гудамж компанийн өөрийн байранд болов.

Хуралд : Д.Нямбаяр 89618 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Л.Цэгмид 51830 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Л.Мягмаржав 3870 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Эн Ди Эм Эм Ди ХХК 96357 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал
Өлзийбаяр/

Б.Отгонбаатар 2360 ширхэг хувьцааны саналаар /итгэмжлэлээр Б.Анхбаяр/

Ж.Энхтунгалаг 1 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

244036 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 82.5% хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүд болох Төрсайхан,
С.Мөнхгэрэл, Д.Бямбажал нар өөрийн биеэр оролцов.

Хурлыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Л.Мягмаржав удирдав.

Хурлаар:

- Компанийн 2020 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
- Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах:

асуудлыг тус тус хэлэлцэв.

Л.Мягмаржав: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Ариунсайн хурлын ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 82.5% хувьтай байгаа тул Монголын Улсын

хурлыг эхлүүлэх зөвшөөрөлийг хурлын даргад өгөв.

Хурал 16.30 минутанд эхлэв.

СОНССОН НЬ :

- **Хурлын дарга Л.Мягмаржав:** Хурал 4.27 нд болох байсан боловч Созарим хувьцаа эзэмшигчдэд хүндэтгэх шалтгаан байсан учир хурал хойшилсон , одоо хурлаа эхэлье. Ингээд хэлэлцэх асуудлыг уншиж танилцуулья.

- Компанийн 2020 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
- Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах: зэрэг асуудлыг тус тус хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын дагуу **Гүйцэтгэх захирал Д. Нямбаяр:** 2020 оны үйл ажиллагааны тайланг уншиж танилцуулав.

Санхүүгийн үйл ажиллагааны тайланг компанийн **Ерөнхий нягтлан бодогч Н.Одмаа** уншиж танилцуулав.

- **Хурлын дарга Л.Мягмаржав:** 2021 онд ногдол ашиг хуваарилахгүй байх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг уншиж танилцуулав.

Гүйцэтгэх захирал Д.Нямбаяр: Компани маань 2020 онд 20 гаран компанитай хамтран ажиллалаа. Ковидтой холбоотой түрээслэгч компаниуд цөөрсөн 2020 онд төсөвлөгдөж байсан ажлуудаа гүйцэтгэж чадсангүй. Манай компанитай дундаас дээгүүр компаниуд компаниуд хамтран ажиллаж байна. Түрээсэлж болох бүх л дулаан цахилгаан орсон газруудаа түрээсэлж байна. Урд талын 210 гаруй метр кв. талбайг засвар хийж цахилгаан дулааны шийдлийг нь оруулан жижиг оффис хийж хүйтэн граш зориулалтаар түрээслэх бодолтой байна та бүхэнд танилцуулга тараасан байгаа.

Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр: Оффис нь хүйтэн байх юм уу ?

Гүйцэтгэх захирал Д.Нямбаяр: Үгүй ээ оффисын хэсгийн цахилгаанаар халаахаар шийдсэн байгаа

Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр: Ашгийн марж нь ямар байх уу Магадалшгүй ажлын зардал мөн ковидтой холбоотой барилгын материал болон ажлын хөлс нь нэмэгдсэн байгаа энэ төсөв дээр чинь 30% нэмэгдсэн миний бодлоор 300,000 сар болгон нэмэгдээд 500,000 орчин болох байх за тэгээд ийм хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн ч ноогдол ашиг байхгүй ХЭ нарт ямар ч өгөөж байхгүй байна. Хөрөнгө оруулалтын үр өгөөж харагдахгүй байна Ковидын үед төрөөс ус, дулаан, цахилгаан, уур гээд бүгдэд нь хөнгөлөлт үзүүлж байна бизнес ийм хэврэг баймааргүй байна ХЭ зүгээс ашиг хэзээ олох уу өгөөж нь хэр байх уу гэдэг дээр л хүлээлттэй байна.

Гүйцэтгэх захирал Д.Нямбаяр: Миний зүгээс компанид байгаа нөөц бололцоогоо ашиглаад аль нэг эд хөрөнгө зарахгүйгээр бага багаар засвар хийгээд сайжруулаад явах засварлаад түрээслээд явмаар байна эсвэл одоо байгаа энэ чигээр нь байлгаж болно

хөрөнгө оруулалт хийж засварлахийг би эсэргүүцээгүй хөрөнгө оруулалт хийгээд байдаг үүний үр шимийг хэзээ яаж хувьцаа эзэмшигч нар хүртэх вэ? Гэдгийг л танилцуулмаар байна. Хүмүүсийн бөөгнөрөл төвлөрлийг ашиглаад бизнесээ хийвэл зөв байхаа

- **Хурлын дарга Л.Мягмаржав:** Өмнөх ТУЗ-ийн хурал дээр ХЭ Өлзийбаяр ийм санал буюу поректорыг танилцуулсан. Тухайн үед бол танилцуулсан поректор нь төслийн хэмжээнд бас байгаагүй гэхдээ энэ өөрөө 1 зүйл үлдээсэн Өлзийбаяр хувьцаа эзэмшигчээс санаа авсан. Нямбаяр захиралийг өөрөө хийгээч гэж хэлж байсан. Би энэ төсвийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруул гэж хэлсэн. Өлзийбаяр хувьцаа эзэмшигчийн зүгээс санаа оноогоо хэлнэ гэж бодсон миний зүгээс энэ авто машин оношилгоон дээрээ суурилад 210 гаруй метр талбайгаа хамгийн том битүү авто машины худалдааны талбай болгох бусад талбайг ч тийм болгоход үгүйсэхгүй миний санал бол энэ төсвийг дэмжээд ТУЗ-ийн хуралд шилжүүлэх саналтай байна.

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг: Миний хувьд гүйцэтгэх захирлын гаргасан энэ саналыг 100% дэмжиж байна. Нэг амиар хөрөнгө гаргахгүй дотоод нөөц бололцоондоо тулгуурлаад засварын ажлыг эхлүүлэх нь зүйтэй, ЗГ-аас олгож байгаа 3%-ийн зээлээс авбал

- **Хурлын дарга Л.Мягмаржав:** 3%-тай зээл эргэлтийн хөрөнгө, ажилчдын цалин хөлс ажлын байрыг хадгалахад зориулагдсан. Манай компанид тохирохгүй.

Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр: Түрүүн та хэллээ 10 тэрбумын үнэлэмжтэй, компани гэж 40 сая төгрөгийн ашигтай ажиллана гэдэг бол бизнес хамгийн муу үзүүлэлт байна. Тэгэхээр ийм үзүүлэлттэй компанийг ингэж муу ажилуулна гэдэг менежмент байхгүй байна хийх ёстой. Миний байр суурь бол 1ш хувьцаатай хүн хяналтын багц эзэмшиж байгаа хүн бүгдийг нь ашигтай байлгамаар байна. Нямбаяр захиралийг залуучуудыг би ийм баг бүрдүүлсэн гэвэл дэмжээд явмаар байна.

- **Хурлын дарга Л.Мягмаржав:** Өлзийбаяраа бид нар хувьцаа эзэмшигч нарт ашигтай санал байвал бид бүгд 2 гараа өргөөд дэмжээд явна цаашид.

ТУЗ-н хараат бус гишүүн С.Мөнхгэрэл: Би энэ компанийн хараат бус гишүүн Мөнхгэрэл байна. Эздийн хөрөнгө оруулалт гэж юу вэ? Тухайн хөрөнгө оруулалт эдийн засгийнхаа болон өгөөжийнхөө хувьд ямар вэ гэдэг дээр ажиллаж ирсэн хүч байгаа би та бүхнийг өнөөгийн ярьж байгаа тухайн хөрөнгө оруулалтын өгөөжийг нь цаг хугацааны үнэ цэнэтэй уялдуулан шийдвэр гаргаж болохгүй байна одоогийн үүсээд байгаа нөхцөл байдлыг хархад засварын зардал нь бага юм шиг нэгэнд нь санагдаж байна нөгөө төлд хөрөнгө оруулалтын цаг хугацааны үнэ цэнийг өгөөжөөр нь тооцно тавиагүй буюу гүйцэтгэх гэж үзэж байна ямар нэгэн хувилбартайгаар саналаа оруулж ирвэл зөв гэж үзэж байна. Гүйцэтгэх удирдлагын багт хараат бус гишүүний хувиар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллахад татгалзах зүйл байхгүй.

Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр: Би Нямбаяр захиралд санал тавьсан өөрөөсөө хөрөнгө оруулалт хийгээд явъя гэж нэмж хувьцаа гаргахгүйгээр барилгын материалын зах хийгээд оруулсан хөрөнгө оруулалтын компанийн ТУЗ гишүүд, ХЭ нар мэдэж байдаг цаг хугацааны явцад өөрийн оруулсан хөрөнгө оруулалтаа 2-3 жилийн хугацаанд нөхөөд татаад аваад явчдаг түрээсийн орлого болох 18 сая төгрөгийг талаад яваад байхад компани ашигтай ажиллхаар харагдаж байна.

ТУЗ-н хараат бус гишүүн С.Мөнхгэрэл: Номин загвар нь явж байна.

Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр: Компанийг ах, дүү ээж хүүгийх байлагмааргүй байна. Бизнесийг багаар хийдэг болцон. Би чамтай уулзаж ярилцаад баг болж чадахгүйн байна гэдэг бодол төрсөөн.

Хурлын дарга Л.Мягмаржав: Хөрөнгө оруулалтын талаар та тодорхой санал тавина уу. шаардлагатай хөрөнгө оруулалтыг надаас зээлвэл зээл банкнаас зээлвэл бүтэхгүй гэж хэлсэн.

Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр: Энэ төлөвлөгөөгөө 3 жилийн хугацаатай эдийн засгийн тооцойтой болгоод ТУЗ хурлаар оруулж ирмээр байна.

Хурлын дарга Л.Мягмаржав: Өлзийбаяраа ТУЗ дээрээ нарийн хэлэлцүүлэг хийгээд төлөвлөгөөгөө гаргаад нарийн шийдээд явъя.

Хэлэлцэх асуудал дуусав.

Асуух зүйл байна уу.

Байхгүй бол саналаа өгөөд хурлаа завсарлах уу.

Тооллогын комисс саналаа хурааж тоолж дүнгээ гаргаж уншиж танилцуулав.


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2020 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 17 цаг 30 минутанд өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН


/Л.МЯГМАРЖАВ/


/А.АРИУНСАЙН/

